



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 02 өдөр

Дугаар А/423

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 14.2.3 дахь заалт, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1-ийн /Б/ заалт, Малын генетик нөөцийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.3.1, 18.3.4 дэх заалт, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 79 дүгээр тогтоолыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шилмэл мал дэд хөтөлбөрийн хүрээнд бог малын хээлтүүлэгчид үзлэг, ангилалт хийж, баталгаажуулах, Алтайн улаан үүлдрийн ямаа, Сутай үүлдрийн хонины цөм сүргийн малаас өсвөр хээлтүүлэгч бойжуулан сайжруулагчаар сонгон авч, бусад сумдад хуваарилан үржлийн бүртгэл хөтлөн, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга /Г.Гончигсүрэн/-д даалгасугай.

2. Шилмэл мал дэд хөтөлбөрийн төлөвлөгөөнд тусгагдсан заалтуудыг хэрэгжүүлэх бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийж, хянан баталгаажуулах, цөм сүргийн малаас стандартын шаардлага хангасан өсвөр хээлтүүлэгч бойжуулах зардлыг хавсралтаар баталсугай.

3. Шилмэл мал дэд хөтөлбөрийн зардал 10,000,000 төгрөг /арван сая/ -ийн хөрөнгийг хөтөлбөрийн санхүүжилтээс гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.

4. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

Zax A/423.Ch
02 02105

Аймгийн Засаг даргын 2019 оны 07
дугаар сарын 02 –ны өдрийн А/423
дугаар захирамжийн хавсралт

ШИЛМЭЛ МАЛ ДЭД ХӨТӨЛБӨРИЙН
САНХҮҮЖИЛТИЙН ТӨСӨВ

№	Зардлын нэр	Санхүүжилт /мянган төгрөг/	
1	Бог малын хээлтүүлэгчид үзлэг ангилалт хийж, хянан баталгаажуулах зардал	Шатахууны зардал	2890,0
		Томилолт, байрны зардал	3200,0
2	Алтай суманд үржүүлж буй Алтайн улаан үүлдрийн ямааны цөм сүргээс хээлтүүлэгч бойжуулах зардал	Шатахууны зардал	910,0
		Томилолтын зардал	720,0
		Ээмэгний үнэ	440,0
3	Дарви суманд үржүүлж буй Сутай үүлдрийн хонины цөм сүргээс өсвөр хээлтүүлэгч бойжуулах зардал	Шатахууны зардал	680,0
		Томилолтын зардал	720,0
		Ээмэгний үнэ	440,0
Дүн		10000,0	

-oOo-